



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн үйлчилгээний албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг

2023 он

Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал:

Ч.Баярсайхан

Утас: 89000060 Цахим хаяг: bayaraach85@gmail.com

Аудитын менежер: Г.Ганцэцэг

Утас: 88883775 Цахим хаяг: jni.gantsetseg@gmail.com

Ахлах аудитор: Ш.Мөнхцэцэг

Утас: 99799039 Цахим

хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022.08.24 № 13

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ ДАРГА П.СҮХЭЭ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн үйлчилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн үйлчилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Үнэ төлбөргүй 4.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг” шинэчлэн тогтоосон, мөн 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл”-д өөрчлөлт орж цалингийн шатлал нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020126

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	26,204.6	12,656.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,364,993.5	1,299,530.2
	Нийт хөрөнгийн дүн	1,391,198.1	1,312,186.2
	Нийт өр төлбөрийн дүн	590.3	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,390,607.8	1,312,186.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,391,198.1	1,312,186.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	287,167.4	240,320.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	294,407.1	318,742.3
	Үйл ажиллагааны үр дүн	(7,239.6)	(78,421.6)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(7,239.6)	(78,421.6)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,390,607.8
	Тайлант оны үр дүн	-	(78,421.6)
	Эцсийн үлдэгдэл	1,390,607.8	1,312,186.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>235,732.7</u>	<u>234,242.7</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>235,732.7</u>	<u>234,242.7</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	-
	Урсгал зардал	-	-
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	-
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:*Төлбөрийн акт*

Аудитаар нийт 0.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Албан шаардлага

Тайлант хугацаанд 23.7 сая төгрөгийн шилэн дансны мэдээлэл оруулаагүй байна.

Зөвлөмж

Аудитад зөвлөмж өгөгдөөгүй болно.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТШЗ	1	23.8			1	23.8		
Дүн	1	23.8			1	23.8		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТШЗ	1	0.6	1	0.6				
Дүн	1	0.6	1	0.6				
Нийт дүн	2	24.4	2	0.6	1	23.8		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ					1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ					1			